

СЭТГЭЦ НАРКОЛОГИЙН ТАСГИЙН ТАНИЛЦУУЛГА



Манай тасаг нь анх 1975 оны 07 сарын 01 өдөр нэгдсэн эмнэлгийн тасаг болон 15 ортой ,их эмч 1 ,сувилагч 5, асрагч 4 бүгд 10 орон тоотой байгуулагдсан.

БНМАУ-н сайд нарын зөвлөлийн 1975 оны 174-р тогтоолын заалтын дагуу 1975 оноос Ховд, Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Завхан аймгийг харъяалсан аймаг дундын диспансер болон өргөжиж 50 ортой , их эмч 3, сувилагч 9, асрагч 13, хоол зөөгч 1 бүгд 26 хүний орон тоотой ажиллаж баруун аймгуудын хүн амд сэтгэл мэдрэлийн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэн, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх , өвчний явцыг хянаж байх үүрэг бүхий хөдөөгийн ууган диспансер болон ажиллаж эхэлсэн.

БНМАУ-н сайд нарын зөвлөлийн 1987 оны 251-р тогтоолын дагуу наркологийн 10 ор нэмэгдэж 60 ор бүхий сэтгэл мэдрэл, наркологийн аймаг дундын диспансер болон өргөжиж анхны эрхлэгч эмчээр Л. Бадамжав томилогдон ажиллаж байлаа.

1989 оноос баруун 5 аймаг сэтгэл мэдрэлийн нарийн мэргэжлийн эмч, кабинеттэй болсноор Ховд аймгийн хүн амд сэтгэц каркологийн тусламж үзүүлэх болжээ.

1997 оноос одоог хүртэл 12 ортой, их эмч 2, ахлах сувилагч 1, нөхөн сэргээх эмчилгээний сувилагч 1, ээлжийн сувилагч 5, асаргааны асрагч 5, нийт 14 орон тоотойгоор баруун бүсийн хүн амд сэтгэц наркологийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж, өөртөө болон нийгэмд бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй, хүмүүсийг тэдний онцлогт нь тохируулан эмчилгээ асаргаа сувилгаа хийдгээрээ бусад тасгуудаас онцлогтой.

ЗОРИЛГО: Үйлчлүүлэгчдэд ээлтэй, чанартай хүртээмжтэй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх

ЗОРИЛТ:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг
2. Үйлчлүүлэгчдэд ээлтэй эрүүл мэндийг дэмжих тусламж үйлчилгээг бий болгох
3. Мэргэжилтэнүүдийн мэдлэг, ур чадвар, ёс зүйн харилцаа хандлагыг дээшлүүлэх
4. Тасгийн үйл ажиллагааны тохижилт

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

1. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг эмчлэх, оношлох, хянах
2. Архи болон мансууралын асуудалтай хүмүүсийг оношлох, эмчлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
3. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст сувилахуйн тусламж үзүүлэх
4. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст нийгэм хамт олонд тулгуурласан нөхөн сэргээх эмчилгээ, энгийн хөдөлмөрийн дадал эзэмшүүлэх, мэргэшүүлэх

Тасгийн эрхлэгч П.Хосбаяр, **эмчлэгч эмч** М. Хосбаяр, **ахлах сувилагч** Х.Долгор, **Нөхөн сэргээх эмчилгээний сувилагч** Я.Алтанчимэг

Ээлжийн сувилагч нар С.Бүрэнжаргал, Н.Цэндхорлоо, П.Баяртсайхан, З.Батдорж, Б.Гүрсэд

Асаргааны асрагч нар Ч.Наранцэцэг, Н.Гэрэлцэцэг, Ж.Сарангэрэл, Д.Гантуяа, И.Оюунчимэг